Улаанбаатар хотын музейн 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

9097104 СТА3737 9022031489

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны тухай хууль,

Дагаж мөрдөх огноо: 2020.01.02

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2022.07.18

Байгууллагын нэр: Улаанбаатар хотыг музей

Нэгжийн нэр: Захиргаа

Албан тушаалын нэр: Боловсролын ажилтан

Албан тушаалын ангилал, зэрэглэл: ТҮСУ-4

Ажлын цаг: 40

Ажлын байрны албан ёсны байршил: Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 13-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө-37

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

Онцгой нөхцөл: Үгүй

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Хотын түүх соёл, музейн сан хөмрөг, үзүүллэг түр болон байнгын үзэсгэлэнд түшиглэн соёл, боловсрол, олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэх, олон нийтэд чиглэсэн боловсрол, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах

**Албан тушаалын зорилт:**

1.Музейгээс хэрэгжүүлэх боловсролын урт, дунд, богино хугацааны хөтөлбөр боловсруулах, батлуулах, музейн стратеги төлөвлөлтөд тусгах, музейн үзмэр, цуглуулгад түшиглэн зорилтот бүлэгт /цэцэрлэг, бага дунд, ахлах ангийн сурагчид, оюутнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, насанд хүрэгсэд, гэр бүлд/ зориулсан хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах

2.Олон улсын болон үндэсний төсөл хөтөлбөрт оролцох, музейн брэнд бүтээгдэхүүн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах

3.Музейн үйл ажиллагааг нийтэд хүргэх, цахим сурталчилгааг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, үзмэр сан хөмрөгт тулгуурласан

| |
|---|
| судалгаа хийж музейн тайлбарын ажилд оролцох<br>4.Боловсролын ажлын арга зүйн зөвлөмж, аргачлал, гарын авлага материал, үзүүлэн бэлтгэж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах, судалгаа хийх<br>5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх |

| **Зорилт** | **Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | **Хариуцлага, оролцооны хэлбэр**<br>Туслах - **Т**,<br>Хариуцан гүйцэтгэх - **Г**<br>Хянах – **Х**<br>Шийдвэрлэх – **Ш** |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Музейгээс хэрэгжүүлэх урт, дунд, богино хугацааны боловсролын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах<br>2.Хотын түүхийг соёл, боловсрол, танин мэдэхүйн зорилгоор олон нийтэд сурталчлах, олон нийтийн хөтөлбөр зохион байгуулах<br>3.Зорилтот бүлгийн үзэгчдэд чиглэсэн музейн боловсролын хөтөлбөр боловсруулж батлуулан, тасралтгүй явуулах<br>4.Түр үзэсгэлэн, түүхэн тэмдэглэлт өдрүүдэд боловсролын ажлыг тусгай хөтөлбөр гарган зохион байгуулах<br>5.Боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах байгууллагуудтай байгууллагаа төлөөлөн оролцон ажиллах | Боловсролын ажлын хөтөлбөр гарсан байна | ГХШТ |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Олон улсын болон үндэсний төсөл хөтөлбөрт оролцох, эрэл хайгуул хийх<br>2.Музейгээс олон нийтийн сургалт, сурталчилгаанд ашиглах брэнд бүтээгдэхүүн зохиох, хөгжүүлэх, оюуны өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулах<br>3.Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж, хотын соёлыг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах<br>4.Улаанбаатар хотын түүхийн чиглэлээр төрөл бүрийн комикс танин мэдэхүйн ном бүтээл хийх олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн гарсан байна | ГХШ |

| | | | |
|---|---|---|---|
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах<br>2.Музейн үзэгчдийг өргөтгөх, олон нийттэй харилцаа тогтоох, арга хэмжээг зохион байгуулах<br>3.Музей, түүний цуглуулга, үйл ажиллагааны талаар сурталчилгааны ажил хийх<br>4.Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр цахим сурталчилгааг тасралтгүй явуулах, контент үйлдвэрлэлийг хөгжүүлэх<br>5.Музейгээс олон нийтэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх судалгаа хийх, арга замыг тодорхойлох, иргэдээс тандалтын судалгаа хийх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт гаргах | Иргэдэд хүрэх соён гэгээрүүлэх ажлын хүртээмж дээшилнэ. | ГТ |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Үзмэрт тулгуурласан судалгааг хийж боловсролын агуулгыг боловсруулж гарын авлага, зөвлөмж, танилцуулгыг бэлтгэж нэвтрүүлэх<br>2.Боловсролын ажлын арга зүйн зөвлөмж, аргачлал, гарын авлага материал, үзүүлэн бэлтгэж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах тасралтгүй шинийг санаачлан хөгжүүлэх<br>3.Үзүүллэг, үзэсгэлэнг үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж буйг судлах, анхаарах<br>4.Боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтот бүлгийг тодорхойлох, сегментчлэх | Хөдөлмөрийн тухай хууль төрийн албаны тухай хууль холбогдох дүрэм журмын хэрэгжилт хангагдана | ГТ |
| 5 дугаар зорилтын хүрээнд | **Ажлын байрны үндсэн зорилтоос бусад ажлын хүрээнд:**<br>1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал боловсруулах, хамааралтай зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, тайлагнах<br>2.Албан тушаалын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тооцуулах<br>3.Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг чанд мөрдөн ажиллах, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг эмхлэн цэгцэлж, архивлах<br>4.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай сайн биелүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол тайлагнах<br>5.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг чанд сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх, төрийн албан хаагчийн эрх, | Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл бүрдэнэ | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | үүргийг хэрэгжүүлэх<br>6.Байгууллага, мэргэжилтэнгүүдээс зохион байгуулж буй аливаа сургалт, мэдээллийн цаг, олон нийтийн арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцох<br>7.Байгууллагын эд хөрөнгөд ариг гамтай хандан, хариуцсан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх | | |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, | |
| Мэргэжил | Нийгмийн шинжлэх ухааны багш, Хүмүүнлэгийн ухаан, Соёл судлал, сурган-заах арга зүйн мэргэжилтэй. | |
| Мэргэшил | Музей судлал, соёл судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлээр мэргэшсэн байх | |
| Туршлага | Багш, маркетинг, олон нийт, сурталчилгааны ажлын туршлагатай | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулах<br>-Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх<br>-Тоон судалгаанд үндэслэн харицуулалт хийх<br>-Тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх |
| | Асуудал шийдвэрлэх | -Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулах<br>-Хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах<br>-Албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх<br>-Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах |
| | Багаар ажиллах | -Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллээ баг, хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх<br>-Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцааг бий болгох<br>-Маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх<br>-Багийн амжилтыг дэмжиж, бусдад таниулах<br>-Бүтээлч, санаачлагатай ажиллах |
| | Бусад | -Зан харилцааны өндөр соёлтой<br>-Монгол хэл бичгийн дүрэм, найруулга зүйн өндөр мэдлэг чадвартай байх<br>-Албан хэрэг хөтлөлтийн стандартын мэдлэг, ур чадвартай байх<br>-Компьютерийн өргөн хэрэглээний программыг бүрэн ашиглаж чаддаг байх<br>-Илүү цагаар ажиллах, ачаалал даах чадвартай байх |

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ |
|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: |

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br><br>1.Захирал<br><br>2.Менежер | Бусад харилцах субъект<br><br>1. Соёлын Яам<br>2. НЗДТГ<br>3. НСУГ<br>4. Бусад музей<br>5. Нийт албан хаагчид |
|---|---|

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал: Ажлын хэсэг<br>.................. Б.Нарангэрэл<br>(Гарын үсэг)(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2022 оны 07 дугаар сарын 15-ны өдөр | Байгууллагын нэр: Улаанбаатар хотын музей<br><br>Шийдвэрийн огноо: 2022.07.18<br><br>Дугаар: А/43 |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: Улаанбаатар хотын музей

Шийдвэрийн огноо: 2022.07.18

Дугаар: А/43

(тамга/тэмдэг)

.................. П.Даваасүрэн

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр

9097104 СТА3737 9022031489

---oOo---